

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙСЭН ДҮГНЭЛТ

ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хуульд заасан хугацаанд аудит хийж дүгнэлт, тайлангуудыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитаар 252 байгууллагад санал дүгнэлт гаргаснаас Алтанбулаг сумын цэцэрлэг, Зуунмод сумын 5-р сургууль, Худалдан авах ажиллагааны алба гэсэн 3 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт, 29 байгууллага буюу 11.5 хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 220 байгууллага буюу 87.3 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 31671.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10870.2 сая төгрөгийн алдааг залруулж, 574.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 13428.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 49 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар 494 зөвлөмж хүргүүлсэн байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаар.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5825.5 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 95.2 хувь нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.
- Нийт авлага оны эцэст 12185.0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт авлага 3202.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс зээлийн авлага 2071.1 сая төгрөг буюу 64.7 хувийг эзлэж байна. Үүнд гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээл 2105.4 сая төгрөг, Чандмань ДЭХУҮГазрын бараа материал бэлтгэх урьдчилгаа 281.3 сая төгрөг байна.
- Бараа материалын оны эцэст 5211.6 сая төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх оны үлдэгдлээс 423.9 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна.
- Үндсэн хөрөнгө оны эцэст 105981.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт үндсэн хөрөнгийн 31.8 хувь нь Орон нутгийн байгууллагад, 57.9 хувь нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад, 10.1 хувь нь ОНӨҮГазарт, 0.2 хувь нь сангуудын хөрөнгө эзэлж байна.
- Өр төлбөр оны эцэст 4751.4 сая төгрөгөөр тайлагнагдсан. Нийт өр төлбөр өссөн нь Хот байгуулалтын салбарын төсөлтэй хийсэн гадаадын зээлийн хөрөнгийг Азийн хөгжлийн банкаар дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээлийн ашиглалтын тооцоо нийлсэн актыг үндэслэн 2105.4 сая төгрөгийн өр, авлагыг зэрэг нэмэгдүүлэн тусгасантай холбоотой байна.
- Засгийн газрын сан нь оны эхэнд 120821.4 сая төгрөг, оны эцэст 124450.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан.

Орлого, татаас санхүүжилтийн талаар.

ТЕЗахирагчийн 2015 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого 108714.4 сая төгрөгөөр тайлагнагдсан ба өмнөх онтой харьцуулахад 4858.1 сая төгрөгөөр буурсан. Тайлант оны орлогын бүтцийг авч үзвэл татварын орлого 11246.7 сая төгрөг, татварын бус орлого 24419.2 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 73048.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Төв аймгийн ТЕЗ нь 2015 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөгөөр 9626.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 9358.8 сая төгрөгийг авч 267.9 сая төгрөг дутуу, ОНХСангийн орлогын шилжүүлэг 4594.2 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 3817.0 сая төгрөг санхүүжигдэж, 777.1 сая төгрөг дутуу, Тусгай зориулалтын шилжүүлэг төлөвлөгөөгөөр 37611.7 сая төгрөг авахаас, гүйцэтгэлээр 36905.4 сая төгрөг буюу 372.6 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдсэн байна.

Төв аймгийн 2015 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 69317.8 сая төгрөгөөр баталсан ба батлагдсан төлөвлөгөөнд

аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2 удаа тодотгол хийгдсэн. Төв аймгийн ИТХ-ын 2015.12.04-ний өдрийн 11-р хуралдаанаас төсвийн тодотголыг хийхдээ төсвийн орлогын төлөвлөгөөг давж биелүүлсэн буюу тасарсан орлогыг оны эцэст өөрчлөн тодотгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34.2.1 “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон”, 34.2.2 “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон”, 34.2.3 “энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах” гэж заасантай нийцэхгүй байна.

2015 оны аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 13683.1 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 640.7 сая төгрөгийг хасч тооцоход 13042.4 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 101.3 хувиар буюу 164.8 сая төгрөгөөр биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нийт дүнгээр нь 101.3 хувиар биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 15 төрлийн орлогын төлөвлөгөө биелэж, үйл ажиллагааны орлогын татвар, ТТАМАТөлбөр, үндсэн хөрөнгө борлуулсны орлого, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр, хүү торгууль, өмч хувьчлалын орлого зэрэг нь 1.4-52.8 хувиар тасарсан байна.

- Сумын орлогын төлөвлөгөө 2168.6 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2405.5 сая төгрөг буюу 110.9 хувиар биелүүлсэн. Сумдаар нь авч үзвэл 13 сум орлогын төлөвлөгөөг биелүүлж, Баянжаргалан, Баянцогт, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Угтаал, Эрдэнэ, Зуунмод, Цээл, Аргалант, Архуст, Баянхангай сумд 6.4-44.9 хувиар тасалсан.
- Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого төлөвлөгөөгөөр 10708.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 10654.9 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 54.0 сая төгрөг буюу 99.5 хувиар биелүүлсэн байна. Аймагт төвлөрөх орлогыг 12 сум биелүүлж, 15 сум тасалсан байна.
- 2015 онд орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлого төлөвлөгөөгөөр 200.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 184.7 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 16.0 сая төгрөгөөр тасарсан.

Зарлагын талаар.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 9-р хуралдааны 02 тоот тогтоолоор Төв аймгийн 2015 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын нийт хэмжээг 64873.5 сая төгрөгөөр баталсан

Аймгийн 2015 оны зарлагын төлөвлөгөөг 2 удаа тодотгон баталсан байна. Үүнд:

- 🇮🇽 Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 03-р сарын 27-ний 08 тоот тогтоолоор 67958.0 сая төгрөгөөр буюу анхны батлагдсан төлөвлөгөөг 3084.5 сая төгрөгөөр нэмж тодотгосон.
- 🇮🇽 Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12-р сарын 04-ний 08 тоот тогтоолоор 67361.1 сая төгрөг болгон өмнөх тодотгосон төлөвлөгөөнөөс 596.9 сая төгрөгөөр бууруулан тодотгосон.

Сангийн яамнаас 2015 онд зарцуулах төсвийн зарлагыг нийт 69317.8 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан ба Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 69317.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 65148.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 4169.5 сая төгрөг дутуу зарцуулж, биелэлт 93.9 хувьтай байна.

2015 оны төсвийн урсгал зардал гүйцэтгэлээр 4169.5 сая төгрөг хэмнэгдсэн шалтгаан нь:

- 🇮🇽 МУ-ын 2015 оны төсвийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 109, 230 тоот тогтоолын дагуу Сангийн яам нь төсөвт байгууллагуудын зардлын зарцуулах эрхийг 2015 оны 07-р сарын 01-нээс эхлэн нээсэн ба оны эхний 6 сарын зарцуулагдаагүй зардлуудад хязгаарлалт хийснээр урсгал зардлын хэмнэлт 788.1 сая төгрөг
- 🇮🇽 Төсвийн эх үүсвэрийг дутуу санхүүжүүлсэнээс шалтгаалсан хэмнэлт 1204.4 сая төгрөг байна. Энэ нь Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилт нийт дүнгээрээ

706.2 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн ба байгууллагууд жилийн эцэст 498.2 сая төгрөгийг холбогдох төсөвт буцаан төвлөрүүлсэн

- ✚ Төсвийн шилжих үлдэгдлээс зарцуулагдаагүй үлдсэн 650.0 сая төгрөг
- ✚ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын хэмнэлт 1527.0 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Хуваарилагдаагүй зардал, шилжих үлдэгдэл, төсвийн хэмнэлтийн зарцуулалтын талаар

Аймгийн ИТХурлын 2015 оны 10-р хуралдааны 08 тоот тогтоолоор аймгийн 2015 оны төсвийн шилжих үлдэгдлийг 2577.5 сая төгрөгөөр баталж, зардлын жагсаалтын 1-д аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны төлөвлөгөөнөөс шилжиж санхүүжигдэх хөрөнгө оруулалт 7 төсөлд 798.6 сая төгрөг, 2-т шилжих үлдэгдлээр шинээр хийгдэх хөрөнгө оруулалт 9 төсөлд 1250.0 сая төгрөг, 3-т бусад төсөлд 7 арга хэмжээнд 528.8 сая төгрөг баталсан. Мөн тогтоолоор төсвийн хэмнэлтийг 566.1 сая төгрөгөөр, орон нутгийн хувиарлагдаагүй зардалыг 436.2 сая төгрөгөөр баталсанаар өмнөх оноос шилжсэн нийт 3579.7 сая төгрөгийн зардал батлагдсан байна. Энэхүү батлагдсан зардалаас гүйцэтгэлээр 2773.7 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, төлөвлөгөөнөөс 806.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүй байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 2015 оны эхэнд 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 3078.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 3000.6 сая төгрөгийг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй 77.5 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас зарим сумд нь сумын ИТХ-ын шийдвэргүй, Засаг даргын захирамжаар зарцуулжээ.

Тусгай сангийн зарцуулалтын талаар

Аймгийн Засаг даргын тусгай санд аймгийн Хөгжлийн сан, Хүүхдийн төлөө сан, Мал хамгаалах сан, ГХУССан, Соёл урлаг хөгжүүлэх сан, Тариалан дэмжих сан, Байгал хамгаалах сангууд тайлагнагдсан. Эдгээр сангуудын тайлант оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 253.5 сая төгрөг, орлого 146.4 сая төгрөг, зарлага 301.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 98.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн Засаг даргын тусгай сангуудын Аймгийн Хөгжлийн сан, Мал хамгаалах сан, Тариалан дэмжих сангуудын тайлант оны авлагын эхний үлдэгдэл 374.1 сая төгрөг, оны эцсийн үлдэгдэл 374.7 сая төгрөг болж өссөн. Нийт авлагын үлдэгдлийн 96.7 хувь буюу 362.2 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна. Үүнээс Зуунмод Мах боловсруулах үйлдвэрийн зээл 42.7 хувь буюу 119.3 сая төгрөг байна.

ОНӨҮГ-ЫН БҮТЦИЙН ТАЛААР

Төв аймгийн ТЕЗ-ын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв аймгийн Чандмань ДЭХГазар, Зуунмод Мах боловсруулах үйлдвэр, Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГазрууд санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн. Эдгээр газруудаас Зуунмод Мах боловсруулах үйлдвэр болон Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГазрууд нь 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа аудит хийж дүгнэлт гаргуулаагүй байна.

Төв Чандмань -ДЭХ ОНӨҮГазар нь 2015 онд 4432.1 сая төгрөгийн орлогын, 4544.8 сая төгрөгийн зардлын батлагдсан төлөвлөгөөтэй ажилласнаас 5844.2 сая төгрөгийн борлуулалтын 44.4 сая төгрөгийн бусад нийт 5888.6 сая төгрөгийн нийт орлоготой, 5811.8 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 90.0 сая төгрөгийн борлуулалт маркетингийн, 56.6 сая төгрөгийн ерөнхий ба удирдлагын, 7.1 сая төгрөгийн бусад, 19.3 сая төгрөгийн хөрөнгө борлуулсны гарз нийт 5984.7 сая төгрөгийн зардалтай 96.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

- "Баянхошуу" жишиг хорооллын хашаа худалдах, худалдан авах 2014 оны эцсийн авлага 144.1 сая төгрөгийг авлагаар тусгуулж, барагдуулан хариу ирүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны 95 тоот тогтоолоор 9 төрийн албан хаагчидад 2013 оны 7 дугаар сард ашиглалтанд орсон орон сууцыг аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнөөс хасаж, худалдахаар шийдвэрлэсэнийг үндэслэн 267.0 сая төгрөгийн орон сууцыг хөрөнгийн бүртгэлээс хассан боловч авлагаар бүртгээгүй, төлбөрийг төвлөрүүлээгүй.
- Баянцогт сумын үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах 161.5 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахдаа Баянцогт сумын үерийн хамгаалалтын байгууламжийн угсралтын 154.9 сая төгрөгийн ажлыг, барилга байгууламж угсралтын ажил дуусаагүй байхад хүлээн авсан акт үйлдсэн, үндсэн ажлаа гэрээний дагуу хийж гүйцэтгээгүй байхад магадлашгүй ажлын зардал 2.7 сая төгрөгийг магадлашгүй ажлын актыг үйлдэж олгосон, аймгийн Засаг даргын 2015.12.15-ний өдрийн а/531 тоот захирамжаар ажил зогссон байхад 6.5 сая төгрөгөөр нэмэлт гэрээг байгуулах тухай шийдвэр гарч, ажил гүйцэтгэх явцад зайлшгүй шаардлагатай байгаа гэж санхүүжилтийг олгосон байна.
- Манзуширийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулж, менежментийг боловсруулах 30.2 сая төгрөгийг Идеал групп ХХК-д төсөл арга хэмжээг өөрчлөн Төв аймгийн Музейн барилгын өргөтгөл, тогооны суурийн ажлын зураг төсөл боловсруулах ажил гэж гэрээг дүгнэсэн болон хүлээн авсан баримтгүйгээр зарцуулсан байна.
- Зарцуулах эрх, эх үүсвэр батлагдаагүй ажилд тендер сонгон шалгаруулалт явуулсан төсөл арга хэмжээнд аймгийн БОАЖГазар болон СТСХ-ийн албан бичгийг үндэслэн Эко үйлчилгээ ТББ-д Баян-Өнжүүл сум 12.0 сая төгрөг, Өндөрширээт 12.0 сая төгрөг, Бүрэн 2.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн ба Лүн 12.0 сая төгрөгийг өглөгөөр тайлагнасан байна.
- Аймгийн Засаг даргын тусгай сангуудын авлагын үлдэгдлийн 96.7 хувь буюу 374.7 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл эзэлж байгаа нь зээлийн эргэн төлөлтөнд тавих хяналт сул, урьд авсан зээлийн хугацаа хэтрэлттэй байгууллагад нэмж зээл олгосон, зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авахгүй хангалтгүй ажилласан байна
- 2015 оны жилийн эцсээр 27 сумдын СХСангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2552.6 сая төгрөг буюу нийт зээлийн үлдэгдлийн 33.3 хувийг эзэлж байна. Сумдын санхүүгийн албаныхан СХСангийн зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллахгүй байна.
- Мал хамгаалах сангийн нягтлан бодогч 3 удаа солигдоход нэг ч удаа тооллого хийж тооцоо бодоогүй, аймгийн Засаг даргын захирамжаар 5500 ширхэг буюу 22.0 сая төгрөгийн өвсийг үнэгүй тараасан гэх боловч хаана хэнд өгсөн тодорхойгүй, хулгайд алдсан 969 ширхэг буюу 3.8 сая төгрөг, усанд урссан 600 ширхэг буюу 2.4 сая төгрөг, үхэр идсэн 1045 ширхэг буюу 4.2 сая төгрөг, зарсан 1339 ширхэг буюу 5.4 сая төгрөгийг дансанд тушаагаагүй, 2015 онд шинээр авсан 55.0 сая төгрөгийн тооллого тооцоог хийдэггүй, хөгжлийн бодлогын мэргэжилтэн хуваарилж тараадаг, нярав огт оролцдоггүй, тараасан өвсний тооцоо хийгдээгүй зэрэг зөрчлүүд давтагдсаар байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР